МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2017 оны 02 сарын 03 өдөр Дугаар А/34 Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын гэр хороолold 2008 оны 5 дугаар сарын 1-ээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 4 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар батлсугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 404, 620, 994, 2006 оны 115 дугаар захирамжийн хавсралтын 2 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

020000053

Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 03-ны
өдрийн А/34 дугаар захирамжийн 1-р хавсралт

| № | Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн | | | | Газар өмчлөх эрх шилжүүлсэн | | Газрын байршил | Газрын хэмжээ /м2/ | Газрын үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | Овог нэр | Регистр | | | |
| 1 | Цуян | Бархас | Батбаяр | ЗЮ64030916 | А.Отгон | ЗЮ66101163 | Мандал 5-24 | 500 | 1600000 |
| | | | | | Б.Сугирдорж | ЗФ88082619 | | | |
| | | | | | Б.Бямба-Оюун | ЗЮ91020901 | | | |
| 2 | Равдан | Санжмятав | Энхтайван | ЦГ69112927 | Ц.Дашмаа | ЗК93051801 | Аривжих 14-7 | 850 | 2720000 |
| 3 | Жаалай | Арвинсан | Намбар | ЗЮ50100418 | Л.Дүгэржав | ЗЮ50032608 | Айраг 3-27 | 1072 | 3430400 |
| | | | | | Н.Даваажаргал | ЗЮ86080401 | | | |
| 4 | Баяжих | Зандраа | Баярсайхан | КМ60072115 | Ш.Амарсүрэн | ЗК66070304 | Зоог 7-2 | 778 | 2489600 |
| | | | | | Б.Шинэхүү | КМ86053110 | | | |
| | | | | | Б.Багахүү | ЗК87081817 | | | |
| | | | | | Б.Нандинцэцэг | ЗК91061905 | | | |